МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 05 өдөр Дугаар А/320 Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аянганд малаа ниргүүлж, санхүүгийн дэмжлэг хүссэн малчин иргэн Л.Батдаваад 1,000.000 (Нэг сая) төгрөг, Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулагдах "Мэдээлэл технологийн сорилт-2023" улсын ээлжит уралдаан тэмцээнд оролцох Ш.Анужин болон асран хамгаалагч Б.Цэнгэл нарт замын зардалд дэмжлэг үзүүлэх 243.200 (Хоёр зуун дөчин гурван мянга хоёр зуун) төгрөг, санхүүгийн дэмжлэг хүссэн Мөрөн сумын өндөр настан Ш.Дуламсүрэнд 300.000 (Гурван зуун мянган) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 1,543.200 (Нэг сая таван зууг дөчин гурван мянга, хоёр зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

6710010643